

**ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ**  
2018.07.30-08.03

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ-ын "Apple" компанийн хувьцааны ханш өсч, тус улсын индексүүд өсөлттэй хаагдлаа. Хөрөнгө оруулагчид АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаанаас илүүтэйгээр хувьцаат компаниудын 2-р улирлын санхүүгийн тайланд анхаарлаа хандуулжээ.

"Apple" компанийн борлуулалт төсөөлснөөс өндөр байж, тус компанийн нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40%-аар өссөн байна. "Apple" компанийн хувьцаа 2 хоногийн дотор 8 хувиар өсч, зах зээлийн үнэлгээ нь 1 их наяд ам. доллартай тэнцжээ.

Энэ долоо хоногт АНУ-ын ажил эрхлэлтийн тайлан гарч, 7-р сард хөдөө аж ахуйгаас бусад салбарт үйл ажиллагаагаа явуулж буй ажил олгогчид нийт 157 мянган ажлын байр шинээр бий болгов. Ингэснээр ажилгүйдлийн түвшин буурч 3.9 хувьд хүрлээ. Цагийн ажлын дундаж хөлс 7-р сард өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувиар өсжээ.

Лхагва гарагт АНУ-ын Холбооны нөөцийн банкны мөнгөний бодлогын хуралдаан болж, Холбооны нөөцийн банк богино хугацааны бодлогын хүүгээ 1.75 хувиас 2.00 хувийн хооронд хэвээр нь үлдээхээр шийдвэрлэлээ.

**Европ:** АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал даамжирч, Европын компаниудын хувьцааны ханш уналттай хаагдлаа. АНУ-ын Ерөнийлөгчийн Тамгын газар 200 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний БНХАУ-ын бараа бүтээгдэхүүнд ногдуулсан гаалийн татварын хэмжээг 10 хувиас 25 хувь болгоно хэмээн мэдэгджээ.

АНУ-ын "Apple" компанийн хувьцааны ханшийг даган Европын мэдээлэл технологийн салбарт үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн байна. Хувьцаат компаниудын 2-р улирлын санхүүгийн тайлан ил болж, банкны салбарын компаниудын хувьцааны ханш өслөө.

Европын бүсийн инфляцийн түвшин төсөөлснөөс өндөр байсан ч, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт таамаглаж байсан түвшинд хүрээгүй байна.

Английн төв банк богино хугацааны бодлогын хүүгээ 0.50 хувиас 0.75 хувь болгон нэмжээ. Бодлогын хүү өсч байгаа өнөө үед Их Британийн иргэдийн дунд кредит карт, овердрафт болон хэрэглээний зээл нэмэгдэж байгаа нь эдийн засгийн тогтвортой бус байдал үүсгэх магадлалтайг зарим эдийн засагчид онцоллоо. Иргэдийн цалин бага хэмжээгээр өсч, инфляцийн түвшин эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэдийн дунд барьцаагүй зээл авалт ихэссэн байна. 6-р сард Их Британийн банкууд иргэдэд нийт 1.6 тэрбум фунтын хэрэглээний зээл олгож, нийт зээлийн үлдэгдэл 213.2 тэрбум фунтэд хүрчээ.

**Япон:** Япон улсын компаниудын хувьцааны ханш уналттай хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг суларч 111.6 болжээ.

Японы төв банк бодлогын хүүгээ харьцангуй уян хатан болголоо. Тэрээр 10 жилийн хугацаатай бондын өгөөжийг -0.2 хувиас 0.2 хувийн хооронд барьж, харин зорилтот түвшинг 0 хувь хэвээр үлдээсэн байна.

**БНХАУ:** АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан даамжирч, Хятад улсын эдийн засаг удааширч байгаатай холбогдуулан юанийн ханш 8 долоо хоног дараалан уналаа.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,532.68	0.97% ▲
Dow Jones	АНУ	25,462.58	0.05% ▲
S&P 500	АНУ	2,840.35	0.76% ▲
Nasdaq	АНУ	7,812.01	0.96% ▲
S&P/TSX	Канад	16,420.24	0.16% ▲
FTSE 100	Их Британи	7,659.10	-0.55% ▼
S&P/ASX 200	Австрали	6,234.80	-1.04% ▼
Nikkei 225	Япон	22,525.18	-0.83% ▼
Hang Seng	Хонг Конг	27,676.32	-3.92% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	110.64
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.69
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.63
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	113.02
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.31
TDBM' 2020	USD	9.3%	106.44

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.079	0.00 ▲
Libor 3M	2.343	0.00 ▲
Libor 6M	2.525	-0.01 ▼
Libor 1YR	2.827	0.01 ▲
US 6M Bond	2.201	0.03 ▲
US 2YR Bond	2.653	-0.02 ▼
US 3YR Bond	2.744	-0.01 ▼
US 5YR Bond	2.828	-0.02 ▼
US 10YR Bond	2.960	0.00 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2018.08.03	Өөрчлөлт
USD	2,457.53	-0.28% ▼
CNY	356.55	-1.45% ▼
EUR	2,841.64	-1.00% ▼
RUB	38.70	-1.05% ▼
KRW	2.18	-1.36% ▼
JPY	21.98	-0.99% ▼

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,214.90	-0.66% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	15.42	-0.45% ▼
Зэс	USD/lb.	276.35	-1.46% ▼
Нүүрс	USD/MT	106.35	-7.87% ▼
WTI газрын тос	USD/bbl.	68.49	-0.71% ▼
Brent газрын тос	USD/bbl.	73.21	-1.51% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.85	2.15% ▲

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. VI	7.20%
Бодлогын хүү	2018. VI	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VI	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VI	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	18.00%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VI	10.20%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 49 компанийн 508.2 сая төгрөгийн 3,125,929 ширхэг хувьцаа арилжигдав.


“Баялаг Найлайх” /BNB/ компанийн хувьцаа 14.99%-аар буюу хамгийн ихээр өсч 410.5 төгрөгт хүрч хаагдсан бол “Ноёт хайрхан” /NIE/ компанийн хувьцаа 20.00%-аар буурч 900 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 456 ширхэг үнэт цаас 46.6 сая төгрөгөөр арилжаалагджээ.


8-р сарын 3-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,386.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,532.68 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.97%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	554.8
Зах зээлийн үнэлгээ	2,386,780.6

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,532.68	0.97% ▲
MSE I индекс	9,518.88	2.01% ▲
MSE II индекс	9,284.34	-2.34% ▼

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	2,688,980	195,582,755
АПУ	216,048	129,914,469
Таван толгой	6,108	51,769,875
Монгол базальт	93,984	34,648,014
Говь	1,228	30,366,460

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Баялаг налайх	410.50	14.99% ▲
Хай Би Ойл	61.50	11.82% ▲
Жинст-Увс	1,500.00	4.90% ▲
Улсын их дэлгүүр	500.00	4.14% ▲
АПУ	602.81	3.93% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ноёт хайрхан	900.00	-20.00% ▼
Хөх ган	89.94	-18.24% ▼
Техник импорт	19,000.00	-13.64% ▼
Ар баянхангай	800.00	-11.11% ▼
Стандарт ноос	450.00	-10.00% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт Капитал	400,545,009.19
Мирэ Эссет Секьюритис Монгол	149,373,716.57
Бумбат-Алтай	103,275,050.21
Ти Ди Би Капитал	100,922,699.20
Гаули	92,451,759.98

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	602.81	641,499
Таван толгой	8,630.00	454,501
МИК	11,000.00	227,803
Говь	24,840.00	193,780
Сүү	241.80	73,891

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-11/04/19-A0230-18	40	4,152,000	103,800	103,800	104	18.000%
2	ZGEB-BD-11/04/19-A0230-18	416	42,481,920	102,120	102,120	104	18.000%

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
11	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
12	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
13	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
14	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
15	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
16	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
17	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
19	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
20	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
23	TAN	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
24	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
25	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
26	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Хөвсгөл алтан дуулга” ХК-иас олон нийтэд зориулан үнэт цаасны танилцуулга хийнэ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хөвсгөл Алтандуулга” ХК нь нэмж гаргах үнэт цаасны олон нийтэд зориулсан танилцуулга 2018 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 16 цагт Блю Скай зочид буудлын 3 давхарт зохион байгуулагдах ажээ.

Тус компани нь нийт хувьцааныхаа 28 хувийг олон нийтэд болон стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгон худалдах бөгөөд татан төвлөрүүлэх хөрөнгөө газар тариалан болон гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах, зээлийн эх үүсвэрийг бууруулах, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэнд зарцуулахаар төлөвлөж байна.

“Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн үнэт цаасны захиалгыг 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 13:00 цаг хүртэл авах аж.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### Айтүүлс ХК-ын удирдлагууд тайлант улирлынхаа үйл ажиллагааны үр дүнг таницууллаа

2018 оны 7-р сарын 30-ны өдөр “Айтүүлс” ХК-ын удирдлагууд ҮЦК-уудын брокер, шинжээчидтэй уулзаж, тайлант улирлынхаа үйл ажиллагааны үр дүнг танилцууллаа.

“Айтүүлс” ХК-ийн харилцагчдын тоо 2016 онд 4,300, 2017 онд 4,900 хүрч байсан бол одоогоор тус компани 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад, дотоодын зах зээлд нийлүүлж 6,000 орчим харилцагчтай болжээ. Ингэснээр тус компанийн борлуулалтын орлого 404.9 сая төгрөгт, нийт ашиг 332.3 сая төгрөгт, харин цэвэр ашиг 62.4 сая төгрөгт хүрчээ.

2017 онд “Айтүүлс” ХК нь Монголбанкны 2017 оны 6-р сарын 29-ны өдрийн “Банкны мэдээлэл технологийн шалгуур үзүүлэлтийн журам”-ын 3.2-ын “Нөөц төвүүд нь үндсэн төв байрлаж байгаа байршлаас хамгийн багадаа 200 км зайтай үндсэн төвд нөлөөлөх боломжтой онцгой нөхцөлд газарзүйн алслагдмал байршилд байна” хэмээн заасны дагуу Дархан хот дахь модулятор дата төвийн парк барих зорилгоор олон нийтээс 1.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн билээ. Тус журмын заалт 2018 онд хэргэжиж эхлэх байсан бол Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 3-р сарын 6-ны өдрийн тушаалаар тус журмын заалтыг 2021 оноос хэрэгжүүлэхээр тогтоосон байна. Ингэснээр Айтүүлс ХК нь Дата төвийн барилгын явцыг яаравчлуулах шаардлагагүй болж, харин түүний оронд “Санхүүгийн дата төв” шинэ төсөл хэрэгжүүлж, ашгаа нөхөх талаар мэдээллээ.

“Санхүүгийн дата төв” төсөл нь 9-р сард ашиглалтанд орохоор төлөвлөгдсөн ба төслийн барилгын ажлын явц 70 хувьтай байгаа аж. Энэхүү төслийн хүрээнд “Айтүүлс” ХК Сүхбаатарын талбайн орчимд байдаг шилэн кабелиудыг ашиглан Монголбанк, “Монгол шуудан” ХК, “Монголын цахилгаан холбоо” ХК зэрэг төрийн өмчийн байгууллагуудын санхүүгийн датаг өөрсдийн серверт байршуулах зорилготой юм. Энэ оны 6-р сараас эхлэн уг төслийг дэлхийн мэдээллийн технологийн тэргүүлэх компани болох IBM компанитай хамтарч гүйцэтгэж байна.

Одоогоор тус компани блокчейн технологид суурилсан UBEX арилжааны платформ, Zeel.mn, Trade.mn, клоудмайнинг зэрэг төслүүд дээр ажиллаж байгаа аж. Мөн тус компани Үндэсний дата төвтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг нэвтрүүлэхээр хамтарч ажиллаж эхэлжээ.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

### Монгол шуудан ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гарлаа

“Монгол шуудан” ХК хот, хөдөө орон нутагт байрлах нийт 39 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа аж.

2018 оны эхний хагас жилийн байдлаар борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.1 хувиар өсч 7.8 их наяд төгрөгтэй, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 29 хувиар өсч 6.7 их наяд төгрөгтэй тэнцжээ. Нийт борлуулалтын орлогын 70 орчим хувийг ложистикийн үйлчилгээний орлого бүрдүүлж байна. Замын-Үүд – Улаанбаатар – Алтанбулаг чиглэлд нийт 8,100 орчим тонн ачаа бараа тээвэрлэж, 1.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 дахин өсжээ. Мөн БНХАУ, ОХУ хоорондын транзит орлогыг 455.8 сая төгрөгөөр төлөвлөж байсан ч, ачааллыг зөв, оновчтой зохион байгуулан ажилласны үр дүнд төлөвлөгөөг 410%-аар давуулан биелүүлж, 1.8 тэрбум төгрөгийн орлого олсон. Ингэснээр нийт ашиг 1.1 тэрбум төгрөгтэй тэнцэж 55.1 хувиар нэмэгдсэн байна.

Энэ оны эхний хагас жилд ерөнхий ба удирдлагын зардал 46.3 хувь буюу 148.1 сая төгрөгөөр буурч, гадаад валютын ханшийн зөрүүний алдагдалгүй ажилласнаар “Монгол шуудан” ХК-ийн цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.2 хувиар өсч 906.7 сая төгрөгт хүрлээ.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

### МИК Холдинг ХК-ийн 2018 оны хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гарлаа

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган дотоод, гадаадын зах зээл дээр борлуулах замаар үйл ажиллагаа явуулж буй “МИК Холдинг” ХК-ийн 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гарлаа.

2018 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар тус компанийн 80.6 хувийг ААН, 19.3 хувийг төрийн өмчит байгууллагууд, үлдсэн 0.1 хувийг иргэд эзэмшиж байна.

“МИК Холдинг” ХК-ийн охин компани болох “МИК ОССК” ХХК нь энэ оны эхний хагас жилд МИК актив – 14 ТЗК” ХХК болон “МИК актив – 15 ТЗК” ХХК-ийг шинээр үүсгэн байгуулж, нийт 268.2 тэрбум төгрөгийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан бонд нэмж гаргажээ. Мөн тус хугацаанд давуу эрхтэй бондын үндсэн төлбөрт нийт 118.6 тэрбум төгрөг, давуу болон энгийн бондын купоны төлбөрт 67.2 тэрбум төгрөгийг төлсөн байна.

Компанийн хүүгийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.7 хувиар өсч 115.6 тэрбум төгрөгтэй тэнцлээ. Компанийн борлуулалт, маркетингийн зардал 4.5 дахин буюу 545 сая төгрөгөөр, ерөнхий ба удирдлагын зардал 41.7 хувь буюу 3.1 тэрбум төгрөгөөр ихэссэн байна. Ингэснээр нийт цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар буурч 30.8 тэрбум төгрөгтэй тэнцжээ.

2018 оны эхний хагас жилийн байдлаар “МИК Холдинг” ХК-ийн нийт хөрөнгө 3 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Ипотекийн зээлээр баталгаажсан бондын хэмжээ нийт хөрөнгийн 91.8 хувийг, өөрийн хөрөнгийн хэмжээ 6.5 хувийг бүрдүүлжээ. Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 7.1 хувиар өсөхөд ипотекийн зээлээр баталгаажсан бондын хэлцлийн хэмжээ 5.9 хувиар өссөн нь нөлөөлжээ.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Эрдэнэс Тавантолгой” IPO амжилттай хийхэд нэг алхам ойртлоо

Олон улсын хөрөнгийн бирж дээр нийт хувьцааныхаа 30 хувьд IPO хийж, хөрөнгө босгохоор төлөвлөж байгаа “Эрдэнэс Тавантолгой” компани 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа даваа гарагт олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд тус компани улсын төсөвт 216.5 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Тодруулбал, энэ оны эхний хагаст 6.8 тонн нүүрс экспортолж, 953 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Улсын төсөвт энэ онд 285 тэрбум төгрөг төвлөрүүлэх “үүрэг” хүлээсэн тус компани зорилтынхоо 78 хувийг хагас жилд багтаан биелүүлжээ. Ингэснээр “Эрдэнэс Тавантолгой” 373.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Оны эцэс гэхэд компанийн цэвэр ашиг хоёр дахин өсөхөөр байгаа аж. Найм дахь жилдээ үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэс Тавантолгой” энэ сарын эхээр 40 сая дахь тонн нүүрсээ олборлосон байна. Компани цэвэр ашгаараа хүлээгдэж буй зарим төслөө өөрсдөө санхүүжүүлэх боломж бүрдэж байгааг “Эрдэнэс Тавантолгой”-н гүйцэтгэх захирал Б.Ганхуяг онцоллоо. Компанийн ашигт ажиллагаа сайжрахад экспортын нүүрсний үнэ өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

Тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой”-н удирдлагууд Зүүн Цанхийн уурхайн нүүрсний үнийн асуудлаар “Чалко трейдинг хонконг” компанитай удаа дараа хэлцэл хийж, худалдааны нөхцөлөө сайжруулсан байна. Ингэснээр 59.33 ам.доллар байсан үнийг 61 ам.доллар болгон өсгөсөн нь ийнхүү ашигтай ажиллах нөхцөл бүрдүүлжээ. Мөн Баруун Цанхийн нүүрсийг нээлттэй сонгон шалгаруулалтаар 69 болон 70 ам.доллараас дээш үнээр тогтоосон нь орлого нэмэгдүүлжээ. Компани 373.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахад эдгээр үнийн өөрчлөлт голлох нөлөө үзүүлсэн байна. Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсноор дэлхийн зах зээл дээр коксжих нүүрсний үнэ өсвөл суурь үнэ өснө. Хэрэв үнэ буурвал суурь үнэ 61 ам.доллараас доош буурахгүй байхаар худалдан авагч талтай “Эрдэнэс Тавантолгой” тохиролцжээ. Ийнхүү “Эрдэнэс Тавантолгой”-н санхүүгийн үзүүлэлт сайн гарсан нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж, IPO амжилттай хийхэд нэг алхам ойртлоо. “Эрдэнэс Тавантолгой” компани энэ онд ажилтан, уурхайчдынхаа цалинг 21 хувиар нэмэгдүүлж, шөнийн цагийн нэмэгдлийг тав дахин өсгөжээ.

IPO хийх бэлтгэл ажлын хүрээнд олон улсын аудитын итгэмжлэгдсэн байгууллагаар аудит хийлгэх, санхүүгийн болон хуулийн зөвлөхүүд, хөрөнгийн биржүүдтэй хамтрах ажлыг эхлүүлж байгаагаа мэдэгдлээ. “Эрдэнэс Тавантолгой” компанийн нийт хувьцааны 15 орчим хувийг 2.5 сая иргэн, 486 аж ахуйн нэгж эзэмшдэг. Үлдсэн 85 хувь төрийн мэдэлд байгаа юм. Тус компанийн нүүрсний экспортын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Өнгөрсөн онд 8.5 сая тонн нүүрс экспортолж, Монгол улсын нүүрсний нийт экспортын 25 хувийг дангаар бүрдүүлсэн. Тэгвэл энэ онд 13 сая тонныг экспортолж төлөвлөгөөтэй ажиллаж байна. Олон улсын хөрөнгийн зах зээл дээр гарахаар зорьж буй “Эрдэнэс Тавантолгой”-н санхүүгийн үзүүлэлт илт сэргэж, цэвэр ашгийн хэмжээ нэмэгдэж байгаа. 2017 онд гэхэд 461 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан тус компани захиргааны зардлаа бууруулж, илүү үр ашигтай ажиллах горимд шилжжээ. Үүний хажуугаар орон нутагтай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд 40 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр болсноо дуулгалаа.

Мөн “Эрдэнэс-Эко уурхай” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. УИХ-аас “Эрдэнэс Тавантолгой” компанийн 30 хувийг бирж дээр гаргах эрхийг Засгийн газарт өгсөн. Хэдий улс төрийн том даваагаа уг компани даван гарч, санхүүгийн үзүүлэлт нь сайжирсан ч коксжих нүүрсний зах зээлээс IPO амжилттай болох эсэх нь шалтгаалах юм.

Коксжих нүүрсний үнэ энэ он гарсаар дэлхийн зах зээлд харьцангуй тогтвортой байгаа. Тэгвэл дунд хугацаанд уг таваар одоогийн үнээ жигдхэн хадгалах төлөвтэй байна. Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын тооцоолсноор олборлолт 2018 онд 196 сая тонн болж, нийлүүлэлт өмнөх жилээс бага хэмжээгээр нэмэгдсэн мэдээлэл өгөөд байна. Харин Asia mining сэтгүүлийн шинэ дугаарт “Металлургийн нүүрсний эрэлт, нийлүүлэлт 2019-2020 онд тэнцэхээр байна” хэмээн бичжээ. Тавантолгой ордын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх “Эрдэнэс Тавантолгой”-н IPO тус компанийн засаглалд хүртэл шинэ уур амьсгал бүрдүүлэхээр байна. Тэрчлэн коксжих нүүрсний үнэ богино болон дунд хугацаанд сулрах эрсдэл бага байгаа нь Засгийн газрын санаачилга бодит ажил болоход дөхөм байх нь.

**Эх сурвалж:** Засгийн газрын мэдээ сонин

### Монголбанкны алт худалдан авалт 399 кг-аар нэмэгджээ

Монголбанк өнгөрсөн 7-р сард 2,132 кг алт худалдан авснаар энэ оны эхнээс хойш нийт 9.34 тонн алт худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үед 8.94 тонн алт авч байснаас 399 кг-аар их буюу 4 хувиар өссөн үзүүлэлттэй юм. 7-р сарын байдлаар 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 97 883.50 төгрөг байв.

Монголбанкнаас “АЛТ-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг өрнүүлээд 2 сарын хугацааг үдээд байна.

Ирэх 10-р сарын 31-ныг хүртэл үргэлжлэх тус аяны зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагууд олборлосон алтаа Монголбанк болон арилжааны банкуудад худалдаж, алт тушаалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн дунд алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг таниулахад чиглэж буйгаараа онцлогтой.

“АЛТ-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өнгөрсөн онд Төвбанк 20 тонн алт цэвэршүүлж, 700 гаруй сая ам.доллараар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлсэн. Харин “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны хүрээнд Алтны сорьцын лабораторийг ирэх 9-р сарын сүүлчээр Баянхонгор, Дархан-Уул аймагт нээх аж. Сорьцын лабораторийг байгуулснаар орон нутагт нь алт худалдан авах боломж бүрдэж, алт тушаалтын нийлүүлэлтийн явц олон шат дамжлага дамжихааргүй болж байна. Түүнчлэн алт үйлдвэрлэгчид Монголбанкны тухайн өдрийн ханшаар алтаа тушаах боломж бүрдэх юм.

Монгол Улсын гаалиар зөвшөөрөлгүй алт гаргах үйлдлийг бууруулах, хариуцлагатай уул уурхайг дэмжих, тэдний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, Монголбанкны худалдан авч буй алтны үнийн талаар болон бусад мэдээллийг олон нийт, байгууллагад хүргэх, таниулахад дээрх аян үр дүн өгнө гэдгийг Төвбанкны удирдлагууд онцолж байна.

**Эх сурвалж:** Montsame.mn

### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.